

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

Хяналтад байгаа тогтоол, шийдвэрийн 2017 оны гүйцэтгэлийн мэдээ  
(Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт)

2017 оны 12 дугаар сарын 08

Улаанбаатар хот

№	Эрх зүйн акт огноо, дугаар:	Заалт	Хэрэгжилт Гүйцэтгэлийн хувь (%)	Хяналтанд байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Үр нөлөө
1	2017-02-03  Дугаар 54  Нийслэлийн Засаг Даргын захирамж	<p>1. Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил"-ийн ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж, явц, үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг нийслэлийн төр, захиргааны нийт байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай.</p> <p>2. Удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг тогтмол зохион байгуулах, уулзалтаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах, уулзалтын тайлан мэдээг холбогдох байгууллага, нэгжид тухай бүр тайлагнаж ажиллахыг нийслэлийн</p>	<p>Нийслэлийн Дотоод аудитын алба нь 2017 оны "Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил"-ийн хүрээнд оны эхний хагас жилд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>1. "Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөр:</p> <ul style="list-style-type: none"> <li>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан хууль сурталчлах сургалтад Захиргааны хэлтсийн дарга Я.Сарансүх хамрагдсан. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газартай хамтарч 2017 оны 05 сарын 19, 29-ний өдрүүдэд байгууллагын нийт албан хаагчдад зориулж, уг хуулийг сурталчлах, таниулах сургалтыг зохион байгуулсан.</li> <li>Зөрчлийн тухай хууль: Уг хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй</li> </ul>	4.1. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг дээд газрын тогтоол, шийдвэр, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан оновчтой боловсруулж,	Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан.

		Нутгийн захиргааны байгууллагуудын нийт удирдлагуудад	<p>холбогдуулан Хууль зүйн яамнаас 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан хууль сургалтчлах сургалтад тус албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч 8 албан хаагч хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Захиргааны хэлтсийн дарга Я.Сарансүх Монголын хуульчдын холбооноос зохион байгуулдаг хуульчийн үргэлжилсэн сургалтын “Үндсэн хууль ба үндсэн хуулийн аюулгүй байдал”, “Компанийн засаглал, түүний илрэх хэлбэр, эрх зүйн орчин”, “Хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох зохицуулалтын хэрэглээ” сэдэвт нийт 2 багц цагийн хичээлд хамрагдсан.</li> </ul> <p>2. Эрхлэх асуудлынхаа чиглэлээрх хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох</p> <ul style="list-style-type: none"> <li>Нийслэлийн Засаг даргын 2016 оны 11 сарын 22-ны өдрийн А/830 дугаар захирамжаар байгууллагын бүтэц, орон тоо, дүрэм шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын дотооддоо мөрддөг дүрэм, журмуудыг шинэчлэн боловсруулах, орон тооны бус бүтцийн нэгжүүдийг шинэчлэн зохион байгуулах, эдгээртэй холбогдуулан захирамжлалын баримт бичигт кодификаци хийх шаардлагыг судалсан. Судалгааны дагуу эхний ээлжинд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, даргын зөвлөлийн журам, архивын дүрэм, албан хэрэг хөтлөлтийн журам зэргийг шинэчлэн найруулж, байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороо, Баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулж, холбогдох захирамжлалын баримт бичигт кодификаци хийгээд байна.</li> </ul>	хэрэгжилтийг хангуулах, тайлагнах	
2	2017-12-01 Дугаар А/429	“Авлигын эсрэг нийслэлийн 2017 оны үйл ажиллагааны	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Авлигын эсрэг нийслэлийн 2017 оны үйл	4.1.1. Дээд газрын тогтоол, шийдвэр, Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж, тайлагнах	

	Нийслэлийн Засаг Даргын захирамж	төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.	ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгасан ажлуудыг өөрийн байгууллагын хэмжээнд зохион байгуулж тайланг 2017 оны 12 сарын 11-ний бдрийн 01/175 албан бичгээр НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.		
3	2017-09-12 Дугаар А/687 Нийслэлийн Засаг Даргын захирамж	1.12.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагын дарга нарт:  а/ Нийслэл хотод 2017 онд хэрэгжих инженерийн шугам сүлжээ, авто зам, тохижилтын ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг графикт хугацаанд нь хийж гүйцэтгүүлэх;  б/ Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгын их болон урсгал засварын ажлыг графикт хугацаанд нь гүйцэтгүүлэх, байнгын ашиглалтад хүлээж ажлыг зохион байгуулах;  в/ Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн халаалтын зуухнуудын засвар, шинэчлэлийн ажлуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран халаалтын улирал			

		<p>эхлэхээс өмнө дуусгаж, байнгын ашиглалтад оруулах;</p> <p>г/ Авто зам, явган хүний гарцын гэрэл дохионы найдвартай ажиллагааг хангах, хүйтэн сэрүүний улиралд царцахгүй байхаар телекамер холболтыг шийдвэрлэж, ашиглалтын найдвартай ажиллагааг хангах</p>			
4	<p>2017-09-12</p> <p>Дугаар А/686</p> <p>Нийслэлийн Засаг Даргын захирамж</p>	<p>Нийслэлийн өдрийг угтан харьяалах нутаг дэвсгэр, байгууллагын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг энэ захирамжийн 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөтэй уялдуулан баталж, батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга, харьяа байгууллагын удирдлагуудад даалгасугай.</p>	<p>Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 378 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотын анхны шав тавьсан газар “Мэлхийт” хөшөөнд, “Монголын нууц товчоо”-нд хүндэтгэл үзүүлэх, “Нийслэлийн сүлдэт морин хуур”-ыг цэнгүүлэх, Сүхбаатарын талбайд болсон Төрийн болон Нийслэлийн далбааг мандуулах зэрэг ёслолын ажиллагаа, “Нийслэл-378 жил” хүндэтгэлийн тоглолт тус бүрд албаны удирдлага болон нийт албан хаагчид идэвхтэй оролцсон.</p>		

5	<p>2017-08-18</p> <p>Дугаар А/606</p> <p>Нийслэлийн Засаг Даргын захирамж</p>	<p>Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудаар үйлчлүүлэх иргэн, хуулийн этгээдийн иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, бусад баримт бичгийг эх хувиар нь авчирсан тохиолдолд хуулбарыг нотариатаар баталгаажуулахыг шаардах явдлыг таслан зогсоохыг нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд болон Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа байгууллага, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, холбогдох бусад байгууллагуудын удирдлагад үүрэг болгосугай.</p>	<p>Тус алба нь нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудад дотоод аудит, хяналт шалгалт хийх үндсэн чиг үүргийн хүрээнд ажилладаг. Иймд иргэдэд үйлчилгээ үзүүлдэггүй болно.</p>		
6	<p>2017-05-12</p> <p>Дугаар А/305</p> <p>Нийслэлийн Засаг Даргын захирамж</p>	<p>1.2. Төсвийн шууд захирагч нарт:</p> <p>-Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, мөрдөж ажиллах,</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2014 онд анх боловсруулан, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулан батлаж мөрдөн ажилласан.</p> <p>Байгууллагын орлого, зарлагын гүйлгээг холбогдох стандартын дагуу бүртгэн, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, улирал бүр санхүүгийн тайланг хугацаанд нь гарган, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн баталгаажуулж ажилласан. Нийслэлийн Аудитын газарт</p>		

		<p>-Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр авлага шинээр үүсгэхгүй байх, олон жил болсон өр, авлагыг барагдуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах,</p> <p>-Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр зөрчил гаргасан албан тушаалтнуудад хобогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн доор хариу хүргүүлэх,</p> <p>-Санхүү, бүртгэлийн ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх талаар зохион байгуулж байгаа сургалтуудад холбогдох ажилтныг тухай бүр хамруулах талаар анхаарч ажиллах;</p>	<p>байгууллагын 2016 оны жилийн эцсийн, 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг баталгаажуулж зөрчилгүй санал дүгнэлт авсан.</p> <p>Байгууллагын ахлах нягтлан бодогч бүртгэлийн үйл ажиллагаа, аудитыг хийж гүйцэтгэхтэй холбоотой салбарын холбогдох хууль тогтоомжийг уншиж судлан өдөр тутмын ажилдаа өргөн ашиглаж байна. 2017 онд Санхүүгийн тайлан гаргахад анхаарах асуудал /Сангийн яам, Нийслэлийн төрийн сан/, Нийслэлийн архив, бичиг хэргийн E-doc програмын сургалт /Нийслэлийн Архивын газар/, Татварын эрх зүйн шинэтгэл /Татварын Ерөнхий газар/, L-Monitoring сургалт /НЗДГ-Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс/ тус сургалтад хамрагдаж мэргэшсэн хяналт шинжилгээний сертификат авсан болно.</p>		
7	<p>2017-04-24</p> <p>Дугаар А/252</p> <p>Нийслэлийн Засаг Даргын захирамж</p>	<p>2.3. Албан хэрэг хөтлөлтийн системийн програм хангамж, техник, тоног төхөөрөмж, сүлжээний найдвартай ажиллагааг хангахад шаардагдах хөрөнгийг тухай бүр шийдвэрлэж ажиллахыг нийслэлийн төр, захиргааны байгууллагууд, тэдгээрийн харьяа газар, орон нутгийн</p>	<p>Албан хэрэг хөтлөлтөд ашиглах 3 тоон гарын үсгийн төхөөрөмжийг Нийслэлийн Мэдээллийн технологийн газраас хүлээн авсан.</p>		

		өмчит болон өмчийн оролцоотой үйлдвэр, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгов.			
8	2017-03-30 Дугаар А/171 Нийслэлийн Засаг Даргын захирамж	<p>1. Нийслэл, дүүргүүдийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бол Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг 1 дүгээр, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус олгосугай.</p> <p>2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг, түүний харьяа хэлтсүүдийн дарга нарт тус тус зөвшөөрсүгэй.</p>	Төрийн захиргааны албан хаагчдад олгох зэрэг дэвийг шинээр 1 албан хаагч авч, 6 албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, 3 албан хаагчийн цалингийн шатлал, 1 албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг ахиулж, 1 албан хаагч тангараг өргөж төрийн жинхэнэ албан хаагч болсон.		

9	<p>2017-02-03</p> <p>Дугаар А/54</p> <p>Нийслэлийн Засаг Даргын захирамж</p>	<p>1. “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил”-ийн ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж, явц, үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг нийслэлийн төр захиргааны нийт байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай.</p>	<p>Нийслэлийн дотоод аудитын албаны “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 1/189 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.</p>		
10	<p>2017-01-09</p> <p>Дугаар А/17</p> <p>Нийслэлийн Засаг Даргын захирамж</p>	<p>8. “Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг нийслэлийн төр, захиргааны бүх байгууллага, албан хаагчдад үүрэг болгосугай.</p>	<p>Албан тасалгаанд агаар чийгшүүлэгч төхөөрөмж тавих, Албан өрөө тасалгаанд агаар чийгшүүлэгч тасалгааны цэцэг, ургамал тарьж ургуулах</p> <p>Хавар, намрын бүх нийтээрээ мод тарих ажилд идэвхтэй оролцох</p> <p>Хавар, намрын бүх нийтийн цэвэрлэгээнд хамт олноороо идэвхтэй оролцох</p> <p>Бүх албан хаагчдыг эрүүл мэндийн бүрэн үзлэг, шинжилгээнд хамруулсан. “Сүү” ХК-тай хамтран “Сүүгээр эрүүлжье” сарын аянд 16 албан хаагчийг хамруулав. Энэ аяны хүрээнд албан хаагчдын кальцийн хэмжээг тодорхойлж, өдөр бүр тогтмол 1 аяга сүү, тараг, аарц хэрэглэж байгаа</p> <p>НГБХГ-ын “Сэтгэцийн эрүүл мэнд, стресс менежмент”, “Гэр бүл, хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжлийн эерэг аргууд”</p>		



11	<p>2016-12-28</p> <p>Дугаар 215</p> <p>Засгийн Газрын Тогтоол</p>	<p>2. 2017 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээрээ 3-5 хоног асарсан ажил, хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчид цалинтай чөлөө олгохыг ажил олгогч нарт даалгасугай.</p>	<p>Тус албаны 5 албан хаагчид 2017 оны 1 дүгээр сарын 2-ний өдрөөс мөн оны 3 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд амьсгалын замын цочмог томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээрээ асрахад 3-5 хоногийн цалинтай чөлөөг олгосон болно.</p>		
12	<p>2015-03-06</p> <p>Дугаар А/172</p> <p>Нийслэлийн Засаг Даргын захирамж</p>	<p>1. “Байгууллагын архивын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, хадгалалтын горимыг тогтоож мөрдүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.</p> <p>2. Журмыг 2015 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс байгууллагын архивын үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн харьяа байгууллага, нийслэлийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.</p>	<p>1. Тус алба нь 1 архивын өрөөтэй бөгөөд өрөөг зориулалтын тавиур, шат, гал унтраах багаж хэрэгслээр тохижуулсан болно.</p> <p>2. Байгууллагын архивын үйл ажиллагаанд уг захирамжийг мөрдөн ажиллаж байна.</p>		

13	<p>2015-03-06</p> <p>Дугаар А/177</p> <p>Нийслэлийн Засаг Даргын захирамж</p>	<p>1. “Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам”-ыг хавсралтаар баталсугай.</p> <p>2. Журмыг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон дүүрэг, харьяа газар, орон нутгийн өмчит, төсөвт байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.</p>	<p>Архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтэд уг журмыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд Нийслэлийн Архивын газраас явуулсан 2016 оны нөхөн бүрдүүлэлтийн шалгалтанд 86 хувийн үнэлгээ авсан.</p>		
14	<p>2017-08-08</p> <p>Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</p>	<p>4.Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нь даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг шүүрхай зохион байгуулах, хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу тогтоосон хугацаанд хяналт шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн</p>	<p>Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журам, нийсдэдийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар шинэчлэн баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу 2017 оны үйл ажиллагааны тайлан, биелэлтүүдийг зохих хугацаанд нь гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн.</p>		

		<p>баталгаажуулсны үндсэн дээр тайлагнан, “Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем” /www.unelgee.gov.mn/-д байршуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт;</p> <p>5. 2017 оны хагас жилийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа шийдвэрийг заалт тус бүрээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт</p>			
15	<p>2017.11.09</p> <p>Дугаар 37-04</p> <p>Нийслэлийн Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар</p>	<p>3.1. Байгууллага нэгж бүр салбарын онцлог, хуулиар хүлээсэн үүрэг, Нийслэлийн ИТХ, Засаг даргаас баталсан тухайн байгууллага нэгжийн дүрэм, эрх үүргийн хүрээнд нийцүүлэн байгууллага, хэлтэс алба, ажилтан нэг бүр дээр хөтлөгдөх бүх төрлийн баримтыг заавар, журмын дагуу бүрдүүлж байгууллагын архивт тухай бүр хүлээлгэн өгдөг байх;</p> <p>3.2. Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулж буй гэрэл, зураг дуу авиа, дүрс бичлэг, цахим хэлбэрийн баримт, төсөл, тендер гүйцэтгэл, зураг төсөл,</p>	<p>3.1. Хэлтэс алба, ажилтан нэг бүр дээр хөтлөх бүх төрлийн баримтыг заавар, журмын дагуу бүрдүүлж байгууллагын архивт тухай бүр хүлээлгэн өгөх талаар нийт албан хаагчдад танилцуулав.</p> <p>3.2. Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулж гэрэл зургийг аван байгууллагын вэб сайтад байршуулдаг бөгөөд мэдээллийн технологи хариуцсан ажилтнаас хөтлөх хэрэгт нэмсэн болно. Цахим хэлбэрийн баримтыг хэлтэс тус бүрээс архивт хүлээн авч хэвшсэн.</p> <p>3.3. Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан Нийслэлийн Архивын газар, Орхон их сургуулийн хамтарсан “Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн 5</p>		

		<p>худалдан авах ажиллагааны баримтыг зааврын дагуу бүрэн бүрдүүлж тухай бүр байгууллагын архивт хүлээн авч хэвших;</p> <p>3.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн ажил хариуцсан ажилтныг ажлын байранд мэргэшүүлж тогтвор суурьшилтай, дадлагажуулж, чадваржуулж ажиллах, ажлаас чөлөөлөгдөх үед баримтын тооллогыг хийж байх;</p> <p>3.4. Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэхдээ тухайн жилд үүсэн бий болсон бүх төрлийн баримтыг зааврын дагуу байгууллагын архивт шилжүүлсэн, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг хэрэглэж хэвшсэн бэ, хариутай бичгийн шийдвэрлэлтийн байдлыг тус тус харгалзаж байх;</p> <p>3.5. Архивын баримтын хадгалалтын нөхцлийг сайжруулж, зориулалтын өрөөтэй болох, Архив, албан хэрэг хөтлөлтийн ажил хариуцсан ажилтныг ажиллах нөхцөл, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангамж, 2018 онд багтаан байгууллагын архивыг</p>	<p>долоо хоногийн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, мэргэжлийн гэрчилгээ авсан.</p> <p>3.4. Албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэхдээ тухайн жилд үүсэн бий болсон бүх төрлийн баримтыг зааврын дагуу байгууллагын архивт шилжүүлсэн, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг хэрэглэж хэвшсэн эсэх, хариутай бичгийн шийдвэрлэлтийн байдлыг тус тус харгалзаж үзсэн.</p> <p>3.5. Тус алба нь 1 архивын өрөөтэй бөгөөд өрөөг зориулалтын тавиур, шат, гал унтраах багаж хэрэгслээр тохижуулсан болно. Архивын 2018 оны төлөвлөгөөнд байгууллагын архивыг гэрчилгээжүүлэх талаар тусган ажиллах болно.</p>		
--	--	--	--	--	--

		гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулахыг нийслэлийн Архивын газар /С.Гаваа/-д тус тус үүрэг болгов.			
16	2017.11.09 Дугаар 37-01 Нийслэлийн Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар	Үйлчилгээний бүрдэл материал, шат дамжлага, хууль эрх зүйг судлах, хууль тогтоомж сайжруулах санал боловсруулах, шинээр програм хангамж нэвтрүүлэхгүй байх, одоо ашиглаж байгаа програм хангамжуудыг нэгдсэн програмд уялдуулан хөгжүүлж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудын удирдлагуудад	Манай байгууллагын үндсэн үйл ажиллагаатай шууд холбоотой “Дотоод аудитын тухай хууль”-ийн төсөлд багц санал боловсруулан Монгол улсын Сангийн яам, НЗДТГ-ын ХЭЗХ-т хүргүүлсэн.  Шинээр програм хангамж нэвтрүүлээгүй бөгөөд, албан хэрэг хөтлөлтийн “Edoc”, өргөдөл, гомдлын smartcity програм хангамжуудыг ашиглаж байна. Бүх албан хаагчдыг “Edoc” програмын сургалтад хамруулан, програмд нэвтрэх нэр, нууц код олгон, албан хаагчдыг програм ашиглахтай холбогдсон мэдээлэл, арга зүйгээр тухай бүр ханган ажилласан.		
17	2017-10-25 Дугаар 01 Засгийн Газрын Тогтоол	1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад: 1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг	1.1. Байгууллагын нийт албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид үйл ажиллагаагаа явуулж байна.  Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон “Ёс зүйн дүрэм”-ийг шинээр боловсруулан мөрдүүлэхээр байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороо холбогдох бусад ёс зүйн дүрэм (Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны ёс зүйн дүрэм, дотоод аудиторын ёс зүйн дүрэм, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг ашиг сонирхлын		

		<p>бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах;</p> <p>1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат</p>	<p>зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм)-үүдийг судалж байна.</p> <p>1.2. Байгууллагын дарга Б.Жавзан НЗДТГ, АТГ-ын хамтран зохион байгуулсан “Ёс зүй-сахилга хариуцлага” сургалт, байгууллагын ЭБАТ АТГ-аас зохион байгуулсан “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ны сургалт“-д тус тус хамрагдсан бөгөөд АТГ-т хүсэлт гаргаснаар байгууллагын 17 албан хаагчийг Авлигын эсрэг хууль тогтоомж, төрийн албан хаагчдын ёс зүйн талаар сургалтад хамруулсан.</p> <p>2017 оны байдлаар албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол санал ирээгүй.</p> <p>1.3. Байгууллагад нийт 29 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Дээрх өргөдлүүдийн 3 нь иргэдээс, 26 нь албан хаагчдаас ирсэн өргөдөл бөгөөд 25 өргөдлийг иргэний талд шийдвэрлэж, 3 өргөдөлд шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгсөн.</p> <p>-Байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 21 цаг байгаа нь нь нийслэлийн зорилтот түвшин /9 хоног 23 цаг 59 минут/-д хүрсэн байх бөгөөд нийслэлийн дундаж индексээс 0.044 нэгжээр, нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудаас 0.123 нэгжээр дээгүүр үзүүлэлттэй байна.</p> <p>1.4. Ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалт, бүтээмж, ажлын чанар, үр дүн, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, цагийн бүртгэл, гадуур ажлын бүртгэлийн дэвтэр хөтлөлтийг сайжруулж, албан хаагчдын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхэд дээрх үзүүлэлтүүдийг харгалзсан болно.</p>		
--	--	---	---	--	--

		<p>шатандаа тууштай тэмцэх;</p> <p>1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах;</p> <p>1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах:</p>	<p>1.5. Удирдлагын зүгээс албан хаагчдыг тогтвортой ажиллуулах бодлогыг баримталж байгаа бөгөөд байгууллагын батлагдсан 22 орон тоонд багтаан албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдад 2017 онд нийт 3,645.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, тусламж олгож, байгууллагын оны шилдэг ажилтан шалгаруулан, 7 албан хаагчийг дээд газрын шагналд тодорхойлсон.</p> <p>2.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2016 оны үйл ажиллагааны үр дүнг шалган зааварлах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн биелэлтийг тайлагнаж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд хяналтад байгаа дээд гүйцэтгэлийн мэдээг улирал бүр /2 удаа/ гарган L monitoring програмаар хугацаанд нь тайлагнасан.</p> <p>2017 оны эхний 11 сарын байдлаар нийт 12 удаагийн нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 30 төрлийн үүрэг даалгаварын биелэлтийг ханган хугацаанд нь тайлагнасан. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг улирал тутам дээрх програмаар хугацаанд нь тайлагнасан.</p> <p>2.2. Манай байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэгт хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажил байхгүй болно.</p> <p>2.3. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хуудсанд</p>		
--	--	--	--	--	--

		<p>Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих;</p> <p>1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.</p> <p>2. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:</p> <p>2.1. Албан тушаалтны сахилга,</p>	<p>байгууллагын танилцуулга, шинэчилсэн дүрэм, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, утасны дугаар, цахим хаяг, албан хаагчдын мэдээлэл, байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлангууд, цаг үеийн мэдээ мэдээллүүд, дотоод аудитын талаарх ойлголт, гарын авлага, стандарт, заавар, загвар зэрэг мэдээллийг нийтэлсэн. Мөн шилэн дансны тухай хуулийн дагуу аудит, хяналт шалгалтын багт ажилласан албан хаагчдын 96 “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг авч <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд хуулийн хугацаанд оруулсан.</p> <p>2.4. 2017 онд байгууллагын албан хаагчидтай холбоотой ёс зүйн гомдол, зөрчил гараагүй байна.</p> <p>2017 онд байгууллагын албан хаагчидтай холбоотой ёс зүйн гомдол, зөрчил гараагүй бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан бүх ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2.5. Байгууллагын удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажилласан болно.</p> <p>4.Манай байгууллага дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу иргэдэд шууд үзүүлэх үйлчилгээ байхгүй боловч нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудтай ажлын уялдаа холбоогоо сайжруулна.</p>		
--	--	--	---	--	--



		<p>хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах;</p> <p>2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз</p>	<p>5. Албан даалгаврын хэрэгжилтийг сар бүрийн 05-ны дотор дүгнэж, НЗДТГ-ын ХШҮХ-т тайлагнаж байх болно.</p>		
--	--	---	--	--	--

		<p>болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах;</p> <p>2.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;</p>			
--	--	--	--	--	--

		<p>2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх;</p> <p>2.5. Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах.</p> <p>4.Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд</p>			
--	--	--	--	--	--

		<p>үзүүлэх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна.</p> <p>5.Албан даалгаврын хэрэгжилтийг жилийн эцсээр дүгнэж тайлангаа ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож байна.</p>			
18	<p>2017.01.05</p> <p>Дугаар 01-3</p> <p>Нийслэлийн Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар</p>	<p>1.1.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд байнгын хяналт тавьж, нийслэлийн удирдлагуудаас шилжүүлсэн болон эргэж танилцуулах заалттай өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг тухай бүр нийслэлийн удирдлага бүрээр гаргаж танилцуулж байх,</p>	<p>1.1. Байгууллагын дарга Б.Жавзан НЗДТГ, АТГ-ын хамтран зохион байгуулсан “Ёс зүй-сахилга хариуцлага” сургалт, байгууллагын ЭБАТ АТГ-аас зохион байгуулсан “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ны сургалт”-д тус тус хамрагдсан бөгөөд АТГ-т хүсэлт гаргаснаар байгууллагын 17 албан хаагчийг Авлигын эсрэг хууль тогтоомж, төрийн албан хаагчдын ёс зүйн талаар сургалтад хамруулсан.</p> <p>2017 оны байдлаар албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол санал ирээгүй.</p>		

	<p>1.2.Нийслэлийн засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу өргөдөлд дурдсан асуудлыг бүрэн шийдвэрлэж, албан ёсны хариуг өгч ажиллах,</p>	<p>1.2. Байгууллагад нийт 29 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Дээрх өргөдлүүдийн 3 нь иргэдээс, 26 нь албан хаагчдаас ирсэн өргөдөл бөгөөд 25 өргөдлийг иргэний талд шийдвэрлэж, 3 өргөдөлд шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгсөн.</p>		
	<p>1.3.Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон иргэдэд чиглэсэн ажлуудын талаарх мэдээллийг нийтэд хүртээмжтэй хүргэх ажлыг тогтмол зохион байгуулж, иргэдийг тосч үйлчлэх, эелдэг харилцах мэдээллээр бүрэн хангах байдлыг бүх албан хаагчдад хэвшүүлэх,</p>	<p>1.3. Ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалт, бүтээмж, ажлын чанар, үр дүн, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, цагийн бүртгэл, гадуур ажлын бүртгэлийн дэвтэр хөтлөлтийг сайжруулж, албан хаагчдын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхэд дээрх үзүүлэлтүүдийг харгалзсан болно.</p>		
	<p>1.4.Өргөдөл, гомдлын хандалт өндөртэй байгаа болон анхаарал татсан, дахин дахин хандаад байгаа зэрэг асуудлыг шийдвэрлэх тусгайлсан хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ажиллах,</p>	<p>1.4. Удирдлагын зүгээс албан хаагчдыг тогтвортой ажиллуулах бодлогыг баримталж байгаа бөгөөд байгууллагын батлагдсан 22 орон тоонд багтаан албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдад 2017 онд нийт 3,645.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, тусламж олгож, байгууллагын оны шилдэг ажилтан шалгаруулан, 7 албан хаагчийг дээд газрын шагналд тодорхойлсон.</p>		

	1.5.Байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг нийслэлийн зорилтот түвшин /9 хоног 23 цаг 59 минут/-д хүргэж ажиллах,	Байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа нь нь нийслэлийн зорилтот түвшин /9 хоног 23 цаг 59 минут/-д хүрсэн байх бөгөөд нийслэлийн дундаж индексээс 0.044 нэгжээр, нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудаас 0.123 нэгжээр дээгүүр үзүүлэлттэй байна.		
	1.6.Албан бичгийн шийдвэрлэлтийг эрчимжүүлж, холбогдох дүрэм журмыг мөрдүүлэх, албан бичгийн харилцаанд цахим хэрэглээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх,	2017 оны эхний 11 сарын байдлаар байгууллагын хэмжээнд нийт 241 албан бичиг ирсэнээс 82 хариутай бичгийн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт ажилласан. Гадагш явуулсан 173 албан бичгийн бүрдэл, стандартыг ханган боловсруулж, тухай бүр програмд бүртгэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Баримт бичгийн эргэлтийн тайланг 14 хоног тутамд гарган хянасан. Тайлант хугацаанд Захиргааны хэлтсийн хэмжээнд 144 албан бичиг ирснээс хариутай бичиг 63 ирсэн бөгөөд үүнээс 57 бичгийн хариуг хугацаанд хүргүүлж, 6 албан бичгийг хариг хүргүүлэхээр судалж байна. “Edoc” програмаар хэвлэмэл хуудсыг захиалж хэвшсэн бөгөөд 3 удаа нийт 300 ширхэг хэвлэмэл хуудас захиалж, хэвлэмэл хуудасны зарцуулалтад хяналт тавин, бүртгэл хөтөлж, эхний хагас жилийн хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг гаргасан.		
	1.7.Иргэдээс гаргаж байгаа ажил хэрэгч саналыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх			

19	<p>2017.01.24</p> <p>Дугаар 05</p> <p>Нийслэлийн Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар</p>	<p>3. Шалган зааварлах ажлын хэсгээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу гүйцэтгэлийг сайжруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, байгууллагын үйл ажиллггааны түвшин, ажлын үр дүнг дээшлүүлэн ажиллах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнахыг Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит, төсөвт, аж ахуйн тооцоот байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов.</p>	<p>Шалган зааварлах ажлын хэсгээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу гүйцэтгэлийг сайжруулах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан бөгөөд байгууллагын үйл ажиллггааны түвшин, ажлын үр дүнг дээшлүүлэн ажиллах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнасан.</p>		
20	<p>2017.01.04</p> <p>Дугаар 01</p> <p>Нийслэлийн Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар</p>	<p>3.Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад:</p> <p>3.1.Байгууллага тус бүр өөрийн чиг үүрэгт хамаарах захирамжлалын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулж, гүйцэтгэлийн явц, үр дүнг улирал тутам хэлэлцэх, удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг тус тус үүрэг болгов.</p>	<p>3.1. Байгууллагын чиг үүрэгт хамаарах нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, захирамжлалын баримт бичгүүдийн хэрэгжилт, түүний явц, үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг хугацаанд нь 100 хувь биелүүлсэн.</p>		

21	<p>2017.06.22</p> <p>Дугаар 23-08</p> <p>Нийслэлийн Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар</p>	<p>4.Байгууллага тус бүрийн өөрийн чиг үүрэгт хамаарах захирамжлалын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулж, гүйцэтгэлийн явц, үр дүнг улирал тутам байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад үүрэг болгов.</p>	<p>4. Байгууллагын чиг үүрэгт хамаарах нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, захирамжлалын баримт бичгүүдийн хэрэгжилт, түүний явц, үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажилласнаар 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлыг хугацаанд нь 100 хувь биелүүлсэн.</p>		
22	<p>2017.07.17</p> <p>Дугаар 03</p> <p>Нийслэлийн Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар</p>	<p>Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад даалгасугай:</p> <p>1.1. Байгууллагын хэмжээнд 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө боловсруулан, улс, нийслэлийн болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх авто зам, инженерийн шугам сүлжээ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн их, урсгал засвар,</p>	<p>Албан даалгаврын хэрэгжилтийг сар бүрийн 05-ны дотор дүгнэж, НЗДТГ-ын ХШҮХ-т тайлагнаж байх болно.</p>		



		<p>шинэчлэлтийн ажлыг графикт хугацаанд нь гүйцэтгүүлэн, өвлийн улирал эхлэхээс өмнө байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа байгууллага, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллагуудад тус тус үүрэг болгосугай.</p>			
23	<p>2017-05-11 Дугаар А/301 Нийслэлийн Засаг Даргын захирамж</p>	<p>3.2.“Автомашингүй өдөр”-өөр сонгосон талбайд “Ухаалаг зорчилт-Цэвэр агаар” уриан дор автомашины хэрэглээг багасгах, өөр төрлийн зорчих хэрэгслийг сонгох, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулахыг иргэд, олон нийтэд уриалж, нийтийг хамарсан уралдаан тэмцээн, худалдаа, үйлчилгээ зохион байгуулахыг энэ захирамжийн 2, 3 дугаар хавсралтад заасан дүүрэг, Нийслэлийн Засаг даргын</p>	<p>1. Нийслэлийн Засаг даргын 2017.03.17-ны өдрийн А/147 дугаар захирамжаар жил бүрийн 05 дугаар сарын 3 дахь 7 хоногийн Бямба гарагийг бүх нийтээр биеийн тамир, спортыг дэмжих автомашингүй өдөр болгож, “Улаанбаатар марафон” олон улсын гүйлт зохион байгуулж байхаар шийдвэрлэсэн. Улаанбаатар хотод 4 дэх жилдээ зохион байгуулагдаж байгаа олон улсын марафон гүйлтэд Нийслэлийн Дотоод аудитын алба тасралтгүй оролцож ирсэн. “Улаанбаатар марафон 2017” олон улсын гүйлтийн нээлтийн арга хэмжээ 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 09:00 цагт Д.Сүхбаатарын талбайд болсон бөгөөд тус гүйлтийн 5 км зайд Нийслэлийн Дотоод аудитын албаны албан хаагчид амжилттай оролцсон.</p>		

		хэрэгжүүлэгч агентлагийн дарга нарт;			
24	2017-04-07 Дугаар А/196 Нийслэлийн Засаг Даргын захирамж	1.Нийслэлийн авто замын ачааллыг зохицуулах зорилгоор энэ захирамжийн хавсралтад заасан нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажил эхлэх цагийг 08 цаг 00 минут байхаар тогтоосугай.	Энэхүү захирамжийг байгууллагын нийт албан хаагчид 2017 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд дагаж мөрдсөн.		
25	2016-10-07 Дугаар А/709 Нийслэлийн Засаг Даргын захирамж	3. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг нэмэгдүүлэх, үйлчилгээг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах хүчний нөөцийг байгууллагынхаа бүтэц, орон тоондоо багтаан шуурхай зохион байгуулж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад даалгасугай.			
26	2016-08-31 Дугаар А/635 Нийслэлийн Засаг Даргын захирамж	1. Монгол Улсын Засгийн газраас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион	1. Нийслэлийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 31-ний А/635, 2016 оны 10 дугаар сарын 28-ны А/760, 2016 оны 11 дугаар сарын 22-ны А/827 захирамжаар байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар өөрчлөгдсөн. Орон тооны батлагдсан хязгаарт тохируулан		

	<p>байгуулалт, бүтэц, орон тооны хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Байгууллагын дүрмийн төслийг боловсруулж 2016 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор танилцуулан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, батлах арга хэмжээ авахыг энэ захирамжийн хавсралтад заасан Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нарт даалгасугай.</p>	<p>байгууллагын бүтэц, ажлын байрны жагсаалтыг батлан ажилласан.</p> <p>2. Байгууллагын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан байгууллагын дүрмийг шинэчлэн батлуулах ажлын хэсэг байгуулагдан албан хаагчдын саналыг нэгтгэн боловсруулж, НЗД-ын 2016.11.22-ны А/830 захирамжаар батлуулан байгууллагын үйл ажиллагаанд мөрдөн ажилласан.</p>		
--	--	--	--	--